

МОНГОЛЫН АРДЧИЛСАН ӨӨРЧЛӨЛТИЙН ҮЙЛ ЯВЦ БА НАМЫН СИСТЕМИЙН ТӨЛӨВШИЛ

Х.Цэнгэлтуяа*

1980-90-ээд оны зааг үеэс Зүүн Европын социалист хэмээх тодотголтой олон улс орон ардчиллын замаар замнах болсоноор С.П.Хантингтоны “ардчиллын гурав дахь давалгаа” хэмээн нэгэнтээ оноон томъёолсон дэлхий дахиныг хамарсан өөрчлөлтийн үйл явцад хүчирхэг түрлэг болсон билээ. Ардчиллын гуравдугаар давалгаа нь 1974 онд Португалд эхэлсэн цэргийн эргэлтээр эхэлж, Өмнөд Солонгос, Унгар, Зүүн Герман, Монгол зэрэг нийт 26 улс орныг хамарчээ. 1974–1990 оныг хүртэлх нийт 15 жилийн хугацаанд энэ үйл явц Өмнөд Европыг хөндлөн гулд туулж, Латин Америкаар дайрч, Зөвлөлтийн дэглэмийн бутралыг эхлүүлж, улмаар Ази руу зүглэж Монголд шууд нөлөөлсөн байна. Эдгээр улс орнуудад ардчилал үүсэн бий болох олон олон учир шалтгаан байсны дотор эдийн засгийн хөгжил дэвшил, аж үйлдвэржилт, хотжилт, хөрөнгөтөн болон нийгмийн дунд ангийн хүрээний өргөжилт, ажилчин анги түүний эрх ашгийг хамгаалагч байгууллагын хөгжил, эдийн засгийн тогтворгүй байдлын аажим уналт зэрэгтэй холбоотой байлаа. (Хантингтон, 1991). Ингэж С.П.Хантингтоны тодорхойлсон ардчиллын гурав дахь давалгаанд Монгол орон 80-90-ээд оны зааг үеэс татагдан орсон байна. Монгол дахь ардчилсан шилжилтийн онцлог нь С.П.Хантингтоны бичсэнчлэн улс төр, эдийн засгийн өөрчлөлт орон зай, цаг хугацааны хувьд давхцан хэрэгжсэнд оршдог. Энэ агуулгаараа Монгол орон улс төр, эдийн засгийн ардчилсан шинэчлэлтийг үлгэр жишээч хослуулан хэрэгжүүлсэн Азийн цорын ганц ардчилсан орон хэмээн үнэлэгдэх болсон. Тийм ч учраас манай орныг Өрнөдийн томоохон судлаачид Ази дахь “шинэ ардчиллын арал” хэмээн хүлээн зөвшөөрөх болсон нь анхаарал татаж байна.

Монголын ардчилсан өөрчлөлтийн нэгэн чухал бүрдэл элемент нь улс төрийн олон намын тогтолцоо мөн бөгөөд Монголын өнөөгийн намууд нь ардчиллыг хэрэгжүүлэх үйл явцын ардчилсан институциональ суурь тулгуурын үүрэг гүйцэтгэж буй билээ. Өнөөдөр Монголын ардчиллыг улс төрийн намуудгүйгээр төсөөлөх аргагүй. Ийм нөхцөлд Монголын ардчилал, нам, намын системийн харилцан хамаарал, тэдгээрийн төлөвшил, хөгжлийн асуудал нь улс төр шинжлэлийн сонирхол татсан асуудал болох нь илэрхий.

* Х.Цэнгэлтуяа - БНСУ-ын Чуннам Их сургуулийн докторант

Монголын ардчиллын төлөвшил

Сүүлийн үед Өрнөдийн томоохон улс төрийн шинжээчид дэлхийн улс орнуудын хүрээнд хийгдэж буй ардчилсан өөрчлөлтийн үйл явцыг дотоод агуулгаар нь өөрчлөлтийн хэд хэдэн онцлог үеүүдэд зааглан харьцуулж, дүн шинжилгээ хийх болсон. Үүнтэй холбогдуулан “*Азийн Барометр*” судалгааны хүрээн дэх “*Зуун Ази дахь ардчиллын чанар ба дэглэмийн легитим чанар*”-ын судалгааны багийнхны баримжаа болгож буй арга хандлагыг онцлон үзэхэд сонирхолтой байна. Тэдний үзэж байгаагаар “сүүлийн 20 жилийн турш ардчилсан шилжилт, ардчиллын нягтрал, ардчиллын чанар гэсэн гурван ойлголтын дагуу дэлхий дэх улс төрийн өөрчлөлтөд дүн шинжилгээ хийж ирсэн” байна.¹ Энэ үүднээс үзвэл Монголын өнөөгийн ардчилсан өөрчлөлтийн үйл явцыг тэдний санал болгосон *ардчилсан шилжилт; ардчиллын нягтрал; ардчиллын чанар* гэсэн агуулгаар шинжлэн үзэх нь зохистой хэмээн үзэж буй болно.

Ардчилал өндөр хөгжсөн, өөрчлөлтийн олон зуун жилийн туршлага бүхий ихэнх улс орнуудын хувьд ардчиллын *шилжилт* буюу *ардчилалтай танилцах, ардчиллыг нягтруулах* замналыг хэдийнээ туулж бараад одоо энэ үндсэн дээр түүнийг *чанаржуулах* зорилтыг шийдвэрлэж буй нь тэдгээр улс орнуудын хувьд нийтлэг хандлага болж байна. Харин ардчиллын замаар замнаад төдий л удаагүй, посткоммунист манайх шиг улс орнуудын хувьд ардчилсан өөрчлөлтийн үйл явцын өрнөлт цаг хугацаа, туулсан замнал нь харилцан адилгүй, ялгаа бүхий байгааг онцлох хэрэгтэй. Тэдгээр улс орнуудын зарим нь ардчилалтай танилцахаас нягтруулах үед шилжих зурвас үед байхад нөгөө хэсэг нь ардчиллыг нягтруулах төвөгтэй зорилтуудыг шийдвэрлэж эхлээд байна. Үүнтэй холбогдон тэдгээр улс орнуудын ардчиллын замналын асуудал маргаан хэлэлцүүлгийн том сэдэв болсоор байна.

Монголын ард түмэн өнгөрсөн зууны 80-90-ээд оны зааг үеэс ардчиллыг хөгжлийн гол зам гэж үзээд эргэлт буцалтгүй сонгосон. Монгол орон өнөөдөр хүн төрөлхтний нийтээр хүлээн зөвшөөрсөн ардчиллын үнэт зүйлст суурилсан өөрчлөлтийг хийж байна. Өнгөрсөн 90 оны дунд үетэй харьцуулахад ардчилал нь үзэл санаа, оргилуун хүсэл зоригоос халин гүнзгийрч, олон түмний аж байдал, үйл хэрэг амьдралын хэрэгцээний түвшинд очжээ. Монгол Улс ардчилсан өөрчлөлтийн үйл явцад шилжсэнээс хойших хорь орчим жилийн хугацаанд манай ард түмэн ардчилсан өөрчлөлтийн гарааны баттай суурь үндсийг бүрдүүлж, нийгмээ ардчилсан нээлттэй зарчмын дагуу шинэчлэн өөрчлөх зүй ёсны үйл явцын эхлэлийг тавьж чадсан. Хүний эрх чөлөөний тулгуур зарчмуудыг эрх зүйн хувьд баталгаажуулж, ардчилсан төрийн байгууламжийн бүтцийн үндсийг бүрдүүлэн олон намын тогтолцоог хэлбэршүүлж, нийгмийн ухамсрын хүрээнд

сэтгэлгээний догматизмаас чөлөөт, прагматик сэтгэлгээний хэлбэрт багтай шилжин, улс орныхоо ардчилсан өөрчлөлтийн материаллаг болон оюун санааны суурь үндсийг бүрдүүлж чадсан нь бидний өнгөрсөн хорь орчим жилийн үйл ажиллагааны гол ололт мөн.

Хэдий гийм боловч Монголын ардчиллын одоогийн олсон амжилт, ололт бүхэн өнөөгийн ардчилалд зайлшгүй хэрэгтэй түүний суурь нөхцөл болохоос биш ардчиллын төлөвшилтийн төгс хэмжүүр баталгаа нь хараахан болж чадахгүй юм. 2006-2008 онд хийгдсэн *"Азийн барометр"* судалгааны хоёр дахь шатанд оролцсон судлаачдын байр суурь сонирхол татаж байна. Тэдний үзэж байгаагаар "Зүүн Азийн ардчиллын гурав дахь давалгаанд дэлгэрэнгүй, динамик шинжилгээ хийхдээ бид ардчилах үйл явцыг зөвхөн төлөөллийн байгууллагуудыг бий болгох, ардчилсан Үндсэн хуулийг батлах зэргээр тогтохооргүйгээр олон талт үзэгдэл гэж ойлгож байна² гэсэн нь анхаарууштай юм. Үүнтэй холбогдуулан судлаач Роуз бичихдээ посткоммунист улс орнуудын ардчилсан өөрчлөлтийн хүрээнд бий болгосон болон бий болж буй зарим нэг нааштай суурь эхлэл институциональ үндэс нь үнэн хэрэгтээ тэдгээр улсуудын хувьд төлөөллийн ардчиллын *"техник хангамж"* төдий л зүйл болохоос бус *"программ хангамж"* нь болж чадахгүй байгаа юм.³

Монгол орон хэдийгээр 1990 оны дунд үеэс Фрийдом Хаус (Freedom House) –судалгааны байгууллагын дүгнэлтээр чөлөөт ардчилсан улсын ангилалд багтсан ч (1990-1991 онд 4.0 оноотой буюу чөлөөт бус, 1991-2002 онуудад 2.5 буюу хагас чөлөөт, 2003 оноос 2.0 буюу чөлөөт ангилалд орсон) манайд ардчиллын олон үнэт зүйлс хэрэгжиж, төгс бодит агуулгаараа төлөвших болоогүй байна. Өнөөдөр Монголд ардчилал хэлбэр талаасаа бодитой байгаа болохоос бус агуулга талаасаа сайн зүгширч чадаагүй байгаа билээ.⁴ Үүний илрэл нь дээрх судалгааны байгууллагаас явуулсан шинэчилсэн судалгаагаар Монгол Улс энэ оноос *хагас чөлөөт* ангилал руу ухрах болсон явдал юм.⁵

Монгол Улсын сонгож авсан ардчилсан хөгжлийн чиг шугамыг иргэд тууштай дэмжиж байгаа дүр зураг⁶ ШУА-ийн ФСЭХ, МУИС-ийн Улс төр судлалын тэнхимийн "Альтернатив" төв, Социологийн тэнхимийн "Социологийн академи", Улс төрийн боловсролын академи, "Прогноз" хүрээлэн, "Сант марал" төв зэрэг байгууллагуудаас хийсэн бараг бүх судалгаанаас гарсан байдаг. Энэ нь Монголын ард түмний сэтгэл зүйд ардчиллыг өргөн хүрээнд нягтруулан хөгжүүлэх хүсэл эрмэлзэл багтай бий болсоныг харуулж байна. 1989-1990 онд Монгол Улс ардчилалд шилжсэнийг хүн амын дийлэнх нь зөв /80 орчим %/ гэж үзсэн хэвээр байна. Харин ардчиллын үзэл санаа бодит байдалд хэрэгжиж буйн талаархи үнэлгээ үүнээс доогуур буюу 50-60 хувьтай

байна.⁷ Монголын ардчиллын асуудалд холбогдох хамгийн сүүлийн гэж хэлж болох томоохон судалгаа нь “Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт: Монгол дахь засаглалын төлөв байдал, үнэлгээ” /2005-2006, 2007-2008, 2009-2011/ сэдэвт цогц судалгаа юм. Энэхүү судалгааны дүнгээс олон нийтийн болон шинжээчдийн үнэлгээгээр Монголын ардчилал бодит үзэгдэл болсон хэдий ч бүрэн баталгаажиж, эргэлт буцалтгүй болсон гэхэд эргэлзээ төрөхөөр дүр зураг гарчээ.

2008 онд хийгдсэн “Ардчилсан засаглалын төлөв байдалд гарсан өөрчлөлт. 2007-2008” судалгаагаар тус орон дахь ардчилсан засаглалын төлөв байдлын ерөнхий үнэлгээ 2008 онд 3,00, харин 2010 оны судалгаагаар 3,01 оноогоор илэрхийлэгдлээ. 2005 оноос 2 жил тутам давтамжтай явуулсан гурван удаагийн цуврал судалгааны дүнгээс үзэхэд Монголын ардчилал, ардчилсан засаглалын төлөв байдалд сүүлийн таван жилд мэдэгдэм нааштай өөрчлөлт гараагүй, өөрөөр хэлбэл хаашаа ч эргэж болох эгзэгтэй нөхцөл хэвээрээ хадгалагдсаар байгаа бөгөөд ерөнхий хандлагын хувьд ухрах шинж ажиглагдсаныг харуулж байна.⁸ Үнэлгээгээр гарсан өөрчлөлтийн дүнг товчоолон дараах хүснэгтээр харуулав. /Хүснэгт №1/

Харин олон нийтийн үнэлгээнээс үзвэл Монгол дахь ардчилсан өөрчлөлтийн шинж байдалд дунд зэрэг гэсэн үнэлгээг өгсөн нь судалгаанаас тодорхой байна. Хүснэгтээс үзвэл манайд ардчиллыг улам төгөлдөржүүлж бэхжүүлэх хэрэгтэй нь харагдаж байна. Тэгэхдээ энэ үйл явц уламжлалт нийгмийн инерци сэтгэлгээ хүчтэй, ардчиллын туршлага уламжлал гэхээр зүйл байхгүй манайх шиг улс орны хувьд төвөгтэй өвөрмөц байх нь илэрхий. Монголд өнөөдөр ардчилалтай танилцах “ардчилсан шилжилт”-ийн зорилтуудыг амжилттай шийдвэрлэхийн хэрээр ардчиллыг нягтруулах төвөгтэй зорилтыг шийдвэрлэх хэрэгтэй болж байна.

Хүснэгт №1 Ардчилсан засаглалын төлөв байдал
(Шинжээчидийн үнэлгээ)

Үнэлгээний асуулт	Экспертүүдийн үнэлгээний дундаж оноо			Гарсан өөрчлөлт	Гарсан өөрчлөлт
	2005	2008	2010	2008-2010	2005-2010
1. Иргэний харьяалал, хууль ба эрх	2.8	3.2	3.14	0.39	0.64
2. Төлөөлөл бүхий харилцаатай засаг төр	2.64	2.8	2.69	-0.05	0.17
3. Иргэний нийгэм ба ард түмний оролцоо	2.84	2.93	2.67	-0.10	0.01
4. Улс орны хилийн чанал дахь ардчилал	3.8	3.7	4.00	0.30	0.20
Ардчилсан засаглалын ерөнхий үнэлгээ	3.02	3.0	3.01	0.01	-0.01

Эх сурвалж: Г. Чулуунбаатар. Засаглалд нааштай өөрчлөлт гараагүй байна. Өдрийн сонин. 2011 №103

Эндээс Монголын ардчиллын замналын агуулга үе шат, онцлогийн тухай асуудал зүй ёсоор гарч ирдэг. Энэ асуудлын хүрээнд Монголын ардчилал шилжилтийн ардчилал уу? эсвэл шилжилтийн үндсэн зорилтуудыг нэгэнт шийдвэрлэсэний хирээр өрнөж буй төлөвшилтийн ардчилал уу? гэсэн асуудал зүй ёсоор тавигддаг. Ер нь шилжилтийн ардчиллын тухай асуудал онолын хувьд сонирхолтой төдийгүй ихээхэн маргаан дагуулсан асуудал хэвээр байна.⁹ Тухайлбал судлаачдын нэг хэсэг нь “шилжилтийн үе” хэмээх нь К.Марксын формачын онолтой холбоотой хуучирсан нэр томъёо гэж үзэж байхад нөгөө хэсэг нь шилжилтийн зурвас үе аливаа өөрчлөлтийн явцад зайлшгүй байдаг, шилжилтийн үе бол бодит процесс хэмээж байгаа юм. Гэвч энэ асуудалд бодитой хариу өгөх нь тийм ч амар хялбар биш. Учир нь Монголын ардчиллын явцад “шилжилтийн үе” гэсэн нэр томъёог хэрэглэх эсэх дээр өнөө ч маргаантай, манай судлаачдын байр суурь нэг мөр болж чадаагүй байна.

Хэдий тийм боловч улс төрийн шинжлэх ухаанд боловсроогүй нийгмийг аажмаар зүгшрүүлэн төгөлдөржүүлж, өрнөж буй үйл явцыг зөв гольдрол чиглэлд нь оруулах бүхэл үйл явцыг “шилжилтийн үе” гэсэн нэр томъёогоор танин мэдэхүйн түвшинд тодотгон хэрэглэдэг. Энэ агуулгаар улс төрийн ном зохиолд “шилжилтийн үе”-ийг шинэ зүйлийн тулгуур үндэс бүрдэх, ардчилсан улс төрийн байгууламж хийгээд ардчилсан үнэт зүйлс, үзэл үнэлэмжийн хэлбэршин зүгшрэх бүхэл үйл явцын үргэлжлэн хэрэгжих зурвас үеийг тэмдэглэсэн ойлголт гэдэг утгаар өргөн хэрэглэдэг. Шилжилтийн үе дуусаагүй гэсэн байр суурийг илэрхийлдэг судлаачид Монголын ардчиллыг түүний төлөвшиж гүйцээгүй заримдаг шинжүүд тодорхойлж байна¹⁰ хэмээн үздэг бол шилжилтийн зорилтыг шийдвэрлэсэн гэж үздэг талынхан Монголын ардчиллын нэгэнт бүрэлдэж бий болсон институтциональ болон үзэл сэтгэлгээний суурь үндсийн тухай асуудлыг хөндөж тавьдаг юм.

Монголын ардчилал шилжилтийн төвөгтэй цаг үеийн зорилтуудыг шийдвэрлэж дуусах явцад ардчиллыг нягтруулах амаргүй үед аажмаар шилжих завсрын өвөрмөц зурвас үеийн зааг дээр явж байна гэсэн байр суурьтай байна. Тэгэхдээ энэ “шилжилт”-ийг 90-ээд оны эхэн үеийн шинэ зүйлийг бүрдүүлэх шилжилтийн зорилтуудаас нилээд ялгаатай ардчиллыг нэгэнт бий болсон суурин дээр нь бэхжүүлж, төгөлдөржүүлэх, нягтруулахад чиглэсэн өөрчлөлтийн шинэ бөгөөд амаргүй үе буюу “ардчиллыг нягтруулах үеийн гарааны зорилтуудыг шийдвэрлэх үе” хэмээн томъёолон тодорхойлж болохоор байгаа юм. Энэ түүхэн зорилтыг хэрэгжүүлэхэд урьдын адил улс төрийн намуудын гүйцэтгэх үүрэг, оролцоо онцгой учир холбогдолтой хэвээр байна. Монголын ардчилсан өөрчлөлтийн үйл явцын дээрх онцлог бүхий нөхцөлд нам, намын системийн төлөвшил түүний шинж онцлогийн тухай асуудал сонирхол татах нь зүйн хэрэг.

Өнөөгийн намын системийн шинж онцлог

Монголд 90-ээд оноос олон намын системийн ардчилсан хэлбэр бүрэлдэн бий болсоноос хойш түүний төлөвшилтийн үйл явц өнөө хэр үргэлжилж буй билээ. Харин энэ үйл явц хөгжлийн амаргүй бөгөөд төвөгтэй үедээ явж байна. Тийм болохоор Монголын намын системийн онолын тулгамдсан асуудлын хүрээнд тус орны намын системийн хөгжил төлөвшилтийн өнөөгийн болон хэтийн төлөв хандлагын асуудал онцгой байр суурь эзэлдэг.

Улс төрийн шинжлэх ухааны ном бүтээлүүдэд “*намын систем*” хэмээх ойлголтыг олон талаас нь томъёолон тайлбарласан байдаг ч¹¹ түүнийг засаглал засаглалын харилцаатай шүтэлцүүлэн авч үзэх хандлага хүлээн зөвшөөрөгдсөн чиглэл болсон байна. Сүүлийн үед нам судлаачдын зонхилох хэсэг нь намын системийг бүртгэлтэй болон парламентад суудал авсан намуудын тоогоор бус, харин намуудын бодит засгийн эрхийг хэрэгжүүлэхэд шаардагдах хууль ёсны мандатын тоо, жин нөлөө, парламент дахь намууд хоорондын харилцааны хүрээнд дэх нөлөө, оролцоо тэдгээрийн үйл ажиллагааны нөөц чадавхийг нь их төлөв үндэс болгон авч үзэх болжээ. Тэд энэ баримтлалаа гаргаж тавихдаа намын систем гэдэг нь улс төрийн намуудын жирийн механик нийлбэр биш. Харин энэ нь тоон болон чанарын талын агууламжтай тэдгээрийн зүй зохист бүтэц бүрдэл бүхий нарийн нийлмэл амьд эрч хөдлөлтэй цогцлол мөн гэсэн нам судлалын тулгуур үнэлэмжийг эш үндэс болгодог.

Энэ бүхнээс үзвэл *намын систем* гэдгийг засаглалын харилцааны хүрээнд төрийн бодлого тодорхойлоход бодитой оролцож, тодорхой үүрэг гүйцэтгэхэд хүрэлцэхүйц хууль ёсны мандатаар баталгаажсан зохион байгуулалтын бүтэц бүхий намууд болон намуудын эвслийн харилцан шүтэлцэж, оршин үйлчлэх хэвшиж тогтсон өвөрмөц хэлбэр, тэдгээрийн хүчний харьцаа, байршлын төвлөрсөн илэрхийлэл юм. Энгийн үгээр хэлбэл: намын систем нь улс төрийн системд намуудын засаглалын харилцааны хүрээнд дэх үйл ажиллагаа тэдгээрийн харилцааны үндсэн хэлбэр мөн гэж тодорхойлж болох байна.¹²

Ардчиллын гурав дахь давалгаанд 1990 оны эхээр татагдан орсон Монгол орон ардчилсан шинэтгэлийн үйл явцыг зоригтой эхлүүлэн, ардчиллын оршин тогтнох тулгуур үндэс болсон олон намын системийн бүрдүүлэн төлөвшүүлж чадсан нь өнгөрсөн 20 жилийн том ололт болсон. Үүнээс өмнө Монгол оронд ноёрхогч нэг намын систем үйлчилж, тэр нь өөрийн төр барих онцгой эрх мэдлийг 1960 оны Үндсэн Хуулиар баталгаажуулж байсан. Энэ цаг үед төрийн бүх үйл хэргийг удирдан чиглүүлэх үүрэг гүйцэтгэж байсан МАХН нийгэм дэх олон ургальч үзэл бодлын “*оролцоо, өрсөлдөөн*”-ны зарчмыг бүрэн үгүйсгэж байсан юм.

Ноёрхогч буюу нэг намын системийн өвөрмөц шинж нь нам ба төр хоёрын хоорондын нарийн нягт уялдаа холбоо юм. Энэ шинж нь байгууллагын (institutional) ба үзэл бодлын (ideological) гэсэн хоёр төрлийн хүндрэлийг үүсгэж байсан юм. Тухайлбал “байгууллагын” хүндрэл нь ленинист намтай улсуудад гол төлөв тохиолддог байжээ. Үүний тодорхой жишээ нь Польшид армийн бүх албан хаагчид коммунист намын гишүүд байх ёстой гэсэн тулгалтаар илэрч байжээ. Харин “үзэл бодлын” гэх хүндрэл нь тухайн үед намын үзэл баримтлал нь төрийн бодлогыг тодорхойлж байсанаар тайлбарлагдаж байсан. Тодруулбал Польш, Унгар, Чехословак, Румын, Болгар, Монгол зэрэг зарим нэг оронд коммунист үзэл баримтлал, төрийн бүтэц зэрэг нь ЗХУ-аас шууд туллагдан хуулбарлагдаж байсан байна. (Хантингтон, 1991).

Монгол орон шинэ ардчилсан Үндсэн хуулиараа 1992 онд олон намын системийг хүлээн зөвшөөрсөн. Ингэснээр тус оронд ардчиллын чухал үнэт зүйлс болсон намууд болон олон ургальч үзэл бодлын оролцоо ба өрсөлдөөн бодит агуулгаараа хэрэгжих бололцоотой болсон юм. Ардчилалыг намуудын оролцоо ба өрсөлдөөнгүйгээр төсөөлөх аргагүй бөгөөд намуудын өрсөлдөөн нь засгийн газрын үйл ажиллагааг идэвхитэй, тэнцвэртэй байлгах чухал механизм болдог байна. Өнөөдрийн байдлаар улс төрийн 18 нам байгаа нь Ж.Сарторийн онол ёсоор Монгол нь таваас дээш буюу олон намын системтэй гэж харагдаж байна.¹³ Гэхдээ энэ нь зөвхөн өнгөц хэлбэрийн төдий байгаа нь тэдний өдөр тутмын үйл ажиллагаа, төрийн хэрэгт оролцож буй байдал, олон нийт дундах нэр хүнд зэргээс нь харагдаж байна. Үүнээс үзэхэд Монголын намын систем нь 1990 оноос хойш нэг намын системээс олон намын систем рүү хэлбэрийн хувьд шилжсэн мэт боловч голлох хоёр намаас бусад нь үзэл баримтлалын хувьд тодорхойгүй, үйл ажиллагаа нь зөвхөн УИХ-ын сонгуулийн үеэр л сэргэдэг, жижиг намууд сонгуульд оролцох үүднээс л АН болон бусад намуудтай эвсэл байгуулдаг зэргээс дүгнэлт хийж үзэхэд манай ихэнх улс төрийн намууд бүрэн төлөвшиж амжаагүй байгааг нотлож байна. Ингэхлээр Ж.Сарторийн онолын жишгээр Монголын намын системийг “олон намын систем” гэхээсээ илүү ерөнхийдөө “хоёр ба хоёр хагас намын систем” гэж үзэж болохоор байдаг юм.

Ардчилсан өөрчлөлтийн явцад тус оронд намын системийн харилцан адилгүй, ялгаа бүхий хэлбэрүүд оршин үйлчилж иржээ. Энэ бүхэн нь 90-ээд оноос өнөөг хүртэл явагдаж өнгөрсөн удаа дараагийн парламентын сонгуулийн үр дүнд бүрэлдэж байлаа. Монголын өнөөгийн намын системийн төлөвшилтийн үйл явцыг агуулгын хувьд ерөнхийд нь дараах байдлаар тоймлон үзэж болох юм. Энэ нь нэгд ардчиллын үйл явцад шилжих шилжилтийн гарааны эхэн үеийн намын

систем. (90 оноос мөн оны дунд үе); хоёрт төлөвшилтийн үндэс тулгуураа олж төлөвших үеийн намын систем. (өнөөгийн болон хожим нэг хэсэгтэй оршин үйлчилж буй хэлбэр); гуравт намын системийн жигдэрч төлөвшсөн хэлбэр (хожим үйлчлэх ирээдүйн намын системийн хэлбэр) зэрэг юм.

Харин Монголын намын системийг тус оронд болж өнгөрсөн парламентын сонгуулийн цаг хугацаагаар зааглан үзвэл энэ нь:

1. Шилжилтийн гарааны эхэн үеийн намын системийн завсрын хэв маяг. (1990-1992 он хүртэл)
2. Зонхилогч намын систем (1992-1996 он хүртэл)
3. Хоёр намын тогтолцоо (1996-2000 он хүртэл)
4. “Нэг нам ба бусад” хэв маяг. (2000-2004 он хүртэл)
5. “Нэг нам зонхилсон хоёр хагас намын тогтолцоо” (2004-2008 он хүртэл)¹⁴

Монголын өнөөгийн парламент дахь намуудын байршлыг авч үзвэл МАН-45 /59,2%/ , АН – 28 /36,8%/ бусад нам, эвсэл 3 /0,04%/ мандагтай байна. Америкийн судлаач Р.Таагепера, М.Шугарт нарын парламент дахь намын үр ашигтай тоо буюу бодит тоон аргачлалаар¹⁵ тооцож үзэхэд МАН-ын парламент дахь жин нөлөө бусад намуудаас илүү байх нь тодорхой байна. 2008 оны парламентын сонгуулийн үр дүнд бүрэлдэж бий болсон өнөөгийн намын системийн хэлбэрийг манайд харилцан адилгүй байдлаар тодорхойлж байгаа билээ. Тухайлбал манай ихэнх судлаачид Монголын өнөөгийн намын системийг “*хоёр намын тогтолцоо*” гэж үзэж байгаа¹⁶ бол нөгөө хэсэг нь тус оронд намын системийн ардчилсан хэлбэр хараахан бүрэлдэн төлөвшиж чадаагүй, харин Америкийн судлаач Ж.Сарторийн 1950-иад оны үеэс судалгааны эргэлтэнд оруулж ирсэн “*ноёрхогч намын систем*” буюу “*хязгаарлагдмал плюрализмын систем*” гэж үздэг.¹⁷ Тэгвэл зарим нь “*нэг нам ноёрхсон дагуул намуудтай систем*” хэмээдэг юм.¹⁸ Тэр ч байтугай Монголд олон намууд бий, харин олон намын тогтолцоо байхгүй гэж үздэг ч судлаачид бий юм.¹⁹ Монголын өнөөгийн парламент дахь намуудын хүчний харьцаа, байршил, харилцааны шинж байдлыг үндэс болгож үзвээс тус оронд өнөөдөр ерөнхийдөө “*хоёр намын тогтолцооны бутцийн хэлбэр*” оршин үйлчилж буй гэж үзэж болохоор байдаг. Гэхдээ манай зарим судлаачид өнөөгийн намын системийн хэлбэрийг хоёр намын системийн цэвэр хэлбэр биш, харин “*хоёр намын блокын буюу зөвшилтийн хэлбэр*” хэмээдэг. Улс төрийн практикаас үзвэл энэ нь хоёр намын тогтолцоотой төсөөтэйгээр үйлчилж байдаг /Герман, Люксембург/ түүний өвөрмөц хэлбэр юм.

Манай парламентад өнөөдөр үнэхээр хоёр намын тогтолцооны цэвэр хэлбэр үйлчилж чадаагүй гэдэгтээ санал нийлж болохоор байдаг. Учир нь хууль тогтоох засаглалын хүрээнд албан ёсны олонх нь МАХН-

ын бүлгийнхэн байх учиртай боловч тэдэнтэй хамтарч парламентын албан ёсны цөөнх хэмээгдэх Ардчилсан намынхан Засгийн газрын бүтцэд орсоноороо үнэн хэрэгтээ тэд парламентын “албан ёсны оппозици” байх статусаа алдаж буй хэрэг юм.

МАХН, АН-уудыг онолын хувьд ямар нэг хэмжээгээр зөрчилдөөнт намууд гэж хэлж болох юм. Нэгэнт зөрчилдөөнт хэв шинжийн намууд гүйцэтгэх засаглалаа хамтран бүрдүүлж буй баримтыг эш үндэс болгож үзвэл манайд Америкийн нэрт судлаач Арэнд Лийпхартын “Плюрал нийгэм дэх ардчилал”²⁰ хэмээх бүтээлдээ анх санал болгосон хоёр намын тогтолцооны “Зөвшлийн буюу эвлэрэл”-ийн хэлбэр оршин үйлчилж байна гэж үзэж болохоор байна. Гэвч хоёр намын тогтолцооны энэ хэлбэр манайд тэр бүр удаан тогтвортой байж чадахгүй гэж үздэг. Хэдийгээр үүнийг цаг хугацаа харуулах боловч дээрх таамаглал үнэний хувьтай байж болох талтай юм.

Манай өнөөгийн засгийн газрыг эвслийн засгийн газар гэж үзэх эсэх асуудал сонирхолтой юм. Америкийн судлаач А.Лийпхарт засгийн газрын танхимыг нэг намын төлөөлөл бүхий олонхийн, олон намын эвслийн танхим гэж ерөнхийд нь ялгаж үзсэн байдаг.

Тэрээр “нэг намын төлөөлөл бүхий засгийн газар, олон намын төлөөлөлтэй өргөн эвсэл нь нэг талаас эрх мэдлийг олонхийн гарт төвлөрүүлэх, нөгөө талд эрх мэдлийг зөвшлийн үндсэн дээр өргөн хүрээнд хуваарилах зарчмын эрс тэс ялгааны бодит биелэл болдог” гэж бичсэн байна.²¹ Харин тэр засгийн газрын эвслийн танхимыг эвслийн онолын үүднээс нарийвчлан үзэж, тэдгээрийг ялимгүй олонхийн эвсэл, жижиг намтай эвсэх, хамгийн цөөн намуудын эвсэл, хамгийн ойр байр суурьтай эвсэл, ялимгүй олонхийн хамтын эвсэл, бодлогод тулгуурласан эвсэл хэмээн тус тус зааглан ялгасан байдаг.

Эндээс эвслийн дээрх онолын үүднээс манай өнөөгийн Засгийн газрыг авч үзэж болох эсэх асуудал урган гарч байгаа юм. Хэдийгээр өнөөгийн засгийн газрыг А.Лийпхартын онол ёсоор “Ялимгүй олонхийн хамтын эвсэл” гэж үзэж болохоор боловч харамсалтай нь манай өнөөгийн Засгийн газрыг эвслийн биш зүгээр л “хэлэлцэж тохиролцсон эвлэрлийн буюу хамтарсан засгийн газар” хэмээн оноон томъёолж болох юм. Эндээс “Эвслийн засгийн газар”, “Эвлэрлийн буюу хамтарсан засгийн газар” хэмээх ойлголтыг агуулгын хувьд нь ялгаж үздэг нь тодорхой байна. Засгийн газрын ийм хэлбэрийг судлаач Майкл Лейсерсон “хэлэлцэн тохиролцох”-д суурилсан эвсэл хэмээн нэрлэсэн байдаг. Үүний гол онцлог нь танхимыг нөлөө бүхий цөөн намууд бүрдүүлдэг, намууд эвслийн биш байдаг, хэлэлцэж тохиролцсоны үндсэн дээр хамтран ажилладаг, танхимын намууд бие биедээ сөрөг хүчин болдоггүй, хамтын шийдвэр гаргадаг зэрэгт оршдог.

Хэдийгээр манай өнөөгийн засгийн газрын танхим нь онолын хувьд стандарт бус шийдвэрт тулгуурласан нь үнэн боловч улс төрийн амьдралын практикаас үзэхэд нэг бус удаа тохиолдож байсан хэв шинж юм байна. /манайд 1990 онд, дэлхийн 2-р дайны үед Их Британид болон бусад зарим улсад/ Харин манай өнөөгийн стандарт бус хэмээх улс төрийн шийдлийг эерэг болон сөрөг аль аль талаас үнэлэн үзэх хэрэгтэй юм.

Намын системийн төлөв хандлага

Намын системийн төлөвшилтийн өнөөгийн шинж байдлыг үндэс болгон Монголын намын тогтолцооны хэтийн төлөв байдлын талаар зарим нэг үндэслэл таамаглалыг дэвшүүлж болох юм. Монголын улс төрийн амьдралын өрнөлт, намын системийн төлөвшилтийн өнөөгийн төлөв байдлыг үндэс болгон үзвээс Монголд намын системийн дараах хувилбар (загвар)-ууд илэрч болохоор байдаг.

- Хоёр гол улс төрийн хүчин ээлжлэн засгийн эрх мэдлийг хэрэгжүүлэх үйл явцаар тодорхойлогддог. “*хоёр намын сонгодог тогтолцоо*”;
- Төрийн засаглалын бодит эрх мэдлийг хоёр гол нам зонхилон хэрэгжүүлэх боловч засаглалын эрх мэдлийг барьж буй болон барилцаж буй намууд гуравдагч хүчний гэгдэх жижиг намуудтайгаа зайлшгүй эвсэн ажиллаж байдаг. “*хоёр хагас намын тогтолцоо*”;
- “*Нэг нам зонхилсон дагуул намуудын тогтолцоо*” эсвэл “нэг нам ба бусад”, “нэг нам зонхилсон хоёр хагас намын тогтолцоо”;
- Аль ч улс төрийн хүчнүүд сонгуульд олонхийн санал аваагүй тохиолдолд их төлөв бүрэлддэг “*эвслийн болон намуудын зөвшилцлийн тогтолцоо*”;
- Парламент дахь намуудын хүчний харьцааны зохистой байдлаар илэрдэг “*олон намын тогтолцоо*” эдгээр болно.

Намын системийн төлөв хандлагын асуудлыг авч үзэхэд анхаарах хүчин зүйлсийн системийн нөлөөллийн асуудлыг тодруулан үзэх ахул өнөөдөр Монголд хоёр намын болон төлөвшсөн цөөвтөр хүчтэй олон намын системийн аль нэг нь үйлчлэх боломж магадлал харагдаж байна. Иймд намын системийн хоёр намын болон олон намын хэлбэрийн оршин үйлчлэх боломжийг тус бүрт нь арай дэлгэрэнгүй авч үзэж шинжлэх шаардлага гарч ирж байна.

Хоёр намын тогтолцоо. Манай ихэнх улс төрчид Монголын ирээдүйн намын тогтолцоог хоёр намын тогтолцоо гэж үздэг. Тэд өнөө үед Монголд ерөнхийдөө хоёр гол нам болох МАХН, Ардчилсан намууд улс төрийн амьдралд зонхилох үүрэг гүйцэтгэж байна. Үүнтэй уялдан Монголын нийгэмд улс төрийн байр суурь, хандлагын хоёр том туйл

бий болсон. Ийм нөхцөлд Монголын улс төрийн амьдралын шинж байдал түүний өрнөлт нь эл хоёр том улс төрийн хүчний харьцаанаас ихээхэн хэмжээгээр шалтгаална гэж үздэг. Үнэхээр ч Монголын улс төрийн амьдралын өрнөлтөөс харахад улс төрийн хүчнүүд сонгуульд оролцоходоо жин, нөлөөллийн хувьд өөрсдөөсөө илүү МАХН-тай өрсөлдөх зорилгын үүднээс аль болохоор өөр хоорондоо эвсэн энэхүү улс төрийн том хүчнийг сөрсөн хүчтэй эвсэл бүрдүүлэх сонирхолтой байдаг нь ажиглагддаг. Үүний илрэл нь удаа дараагийн УИХ-ын сонгуульд намууд оролцоходоо МАХН-ыг сөрсөн хэд хэдэн эвслийг бүрдүүлж байсан нь үүнийг нотлож байна. Тухайлбал 2000 онд намуудын “Ардчилсан холбоо эвсэл”, 2004 онд “Эх орон Ардчилал” эвсэл зэргийг дурдаж болох юм. Залуу улс төрийн хүчнүүдийн энэ бүх эвсэл, хамтын ажиллагааны төвд Ардчилсан нам байдаг нь санамсаргүй хэрэг биш билээ. Цаашдаа ч сонгуулийн явцад намуудын эвсэл бүрэлдэх үйл явц, түүний бодит шаардлага байсаар байх нь илэрхий. Энэ нь аажимдаа Монголын нийгэмд хоёр том нам, эвсэл ямагт голлох нөлөө үзүүлж байх улс төрийн өвөрмөц нөхцөл бүрэлдэх үндэс суурь болж байгаа юм.

Гэвч манай зарим улс төрчид, судлаачид намын системийн өвөрмөц хэлбэр болсон хоёр намын тогтолцоог албан хүчээр улс төрд хэрэгжүүлэхийг оролдох нь хэрээс хэтэрлээ хэмээн шүүмжилдэг. Үүнтэй холбоотойгоор МАХН, Ардчилсан нам хоёр засгийн эрх мэдлийг ямагт ээлжлэн хэрэгжүүлэх сонирхолтой байдаг. Тиймээс ч улс төр дэх гуравдагч хүчний оролцоо, нөлөөллийг зохиомлоор хааж боож байдаг гэсэн шүүмжлэлийг тэд байнга гаргаж тавьдаг юм.

Харин нам судлаачид хоёр намын тогтолцоог нийгэм дэх олон янзын эрх ашиг, сонирхлын хэт ялгарлыг саармагжуулж, тэдгээрийн зохистой тэнцвэртэй байдлыг халгалан, улс төр дэх намчирхал, зохиомол олон хиймэл намууд гарч ирэх үйл явцыг багасгаж хүчтэй намуудын төлөвшлийг түргэтгэхэд ихээхэн ач тустай байдаг хэмээн үздэг. Нэг үгээр хэлбэл хоёр намын тогтолцоо нь улс төрийн намуудын төлөвшилтийн үйл явцын хүрэн дэх намуудын зүй ёсны зохистой шалгарлын үйл явцыг түргэтгэж, нийгэм дэх улс төрийн тогтвортой байдлыг хангахад ихээхэн нөлөө, үүрэг гүйцэтгэдэг хэмээн судлаачид дүгнэдэг юм.

Манай орны хувьд хоёр намын тогтолцооны хэлбэр оршин үйлчлэх магадлал, боломж ихээхэн өндөр байдгийг дурдах хэрэгтэй. Сүүлийн үед Монголын намын системийн хөгжлийн төлөв хандлагыг ажиглаад байхад манайд үндсэндээ хоёр намын тогтолцоо оршин үйлчлэх боломж илүү бодитой харагддаг нь үнэн. Гэвч манай судлаачдын зарим хэсэг нь хоёр намын тогтолцоог Монголын намын системийн ирээдүйн тогтвортой дүр төрх байх болно гэдэгт эргэлзэх нь байдаг. Тэд өөрсдийн энэ байр сууриа илэрхийлэхдээ дараах үндэслэл, тайлбарыг

эш үндэс болгодог. Тухайлбал дэлхийн улс төрийн амьдралын нийтлэг жишгээс үзвэл хоёр намын тогтолцоо нь ардчилал харьцангуй өндөр төвшинд хүрсэн, хүмүүсийн улс төрийн ухамсар, соёл, үнэлэмж баримжаалал нь бодитой бөгөөд тогтвортой, улс төрийн намууд нь жинхэнэ нам шинж төрхөө олж, хэдийнээ цэгцрэн төлөвшчихсэн, нийгэмд эзлэх байр суурь, нөлөө нь хүчтэй, олон түмний итгэлийг хүлээж чадсан тийм улс оронд бодитой, үр нөлөөтэй үйлчлэх бололцоотой гэж тэд үзээд үүнийг наад зах нь ардчилал өндөр хөгжсөн АНУ, Англи, Герман зэрэг улс орны жишээ нотлон харуулж байна гэж тайлбарладаг.

Ардчилалд хөл тавиад удаагүй, энэ талын туршлага, уламжлал гэхээр юм хомс, хүмүүсийн улс төрийн ухамсар, соёл төдий л сайн төлөвшөөгүй, улс төрийн мэдрэмж сулавтар, улс төрийн бодитой үнэлэмж баримжаалал, сонголтын тогтвортой үндэс бүрдэж чадаагүй, хэт улс төржин, туйлшрах нийгэм-сэтгэл зүйн нөлөөлөлд өртөмтгий манай орны хувьд хоёр намын тогтолцоо хүссэн үр дүн өгөхгүй хэмээн тэд үздэг. Үүнтэй холбоотойгоор тэд хэрвээ хоёр намын тогтолцоог манайд зохиомлоор бий болгоход хүрвэл Монголд улс төрийн хэд хэдэн бэрхшээл, сөрөг үзэгдэл гарч болзошгүй гэдгийг онцлон тэмдэглээд энэ нь юуны өмнө нийгмийн оюун санааны амьдралын олон ургальч шинж төрх алдагдаж, түүний зөв тэнцвэрийг хангах бололцоо эргэлзээтэй болж ирнэ. Ийм нөхцөлд улс төр, амьдралын алив асуудлыг гагцхүү үзэл бодлын зөвхөн энэ хоёр хэмжүүрээр авч үзэхэд хүрч, түүний уршгаар нийгэмд намчирхан туйлширч, явцуурах, бүлгэрхэх хандлага хүчтэй болж, улс орны улс төрийн тогтвортой байдал алдагдахад хүрч болзошгүй. Нэг үгээр хэлбэл улс төрийн үнэлэмж байр суурийн ийм хоёр туйл цаашдаа оршин үйлчилсээр байвал манай орны нөхцөлд улс төрийн амьдралын төвд тэмүүлэх хүчний үйлчлэлээс төвөөс зугтаах хүчний үйлчлэл хавьгүй илүү хүчтэй байх магадлал ихтэй юм.

Нөгөө талаас улс төрийн хоёр том хүчний тэнцвэрийг барьж зохицуулах үүрэг бүхий гуравдагч хүчний нөлөө, байр суурийг сулруулж, хүчийг нь хязгаарлах улс төрийн тийм нөхцөл байдал үүсч болзошгүй. Учир нь хоёр намын тогтолцоо нь өөрөө аяндаа улс төрийн гуравдагч хүчний чадвар, чадавхи, хүч нөөцийг хязгаарлаж байдаг сул талтай. Ийм нөхцөлд нөлөө бүхий хоёр том намаас гадна улс төрийн аливаа хүчин гарч ирж, төлөвшин хөгжих цаг хугацаа, орон зайн бололцоо нөхцөл, үнэндээ хязгаарлагдмал байхад хүргэнэ. Ингэхлээр улс орны амьдралын хувь заяа, цаашдын хандлага нь нөлөө бүхий улс төрийн хоёр том хүчний бодит харьцаа түүний өөрчлөлт хувирлаас ихээхэн хамааралтай байх болно. Хэрвээ дээрх нөхцөл үүсэн бүрэлдсэн тохиолдолд манай орны хувьд ардчилал, олон ургальч үзэл, тэгш эрхийн зарчим ямар нэг хэмжээгээр алдагдаж, улс төрийн

амьдралын тогтвортой байдлын баталгаа суларч мэднэ. Тэгээд ч АНУ-д сүүлийн үед хоёр намын тогтолцооны сул талыг шүүмжлэх сэтгэл зүй Америкийн нийгэмд бүрэлдэж байгааг хайхрахгүй байж болохгүй гэж тэд нотлохыг хичээдэг юм. Тиймээс тэд өнөөгийн хоёр намын тогтолцоог задлах нь зүйтэй гэж санал нэгтэй үздэг.

Тэгэхдээ өнөөгийн бодит байдлаас үзвэл хоёр намын тогтолцоог задлахад хэд хэдэн бэрхшээл тохиолдох магадлал бий юм. Энэ **нэгд** Монголд өнөөдөр МАХН, АН-тай өрсөлдөхүйц түвшний улс төрийн төлөвшсөн хүчтэй нам болон намуудын эвсэл байхгүй, **хоёрт** намууд улс төрийн үзэл, байр суурийн хувьд цэгцрэн төлөвшиж чадаагүй. Үүнтэй уялдан намуудын тэр дундаа гуравдагч хүчний намуудын тогтвортой дэмжигч бүлэг нийгэмд бүрэлдэж чадаагүй, **гуравт** нийгмийн сэтгэл зүй үндсэндээ Францын улс төр судлаач Морис Дювержегийн тэмдэглэсэнчлэн хоёр нөлөө бүхий нам түүний тогтолцоонд олон түмний сэтгэл зүй ерөнхийдөө тогтвортой дасан зохицох болсон, **дөрөвт** манай өнөөгийн эрх баригч болон барилцагч улс төрийн хүчнүүдийн эрх баригчид хоёр намын тогтолцоог задлах сонирхолгүй, харин ч түүнийг бэхжүүлэх сонирхолтой байдаг, **тавд** Монголд сонгуулийн ямар ч хэлбэрийг сонгож авлаа гэсэн эцсийн дүндээ судлаач Д.Райн тэмдэглэсэнээр тэдгээр нь нөлөө бүхий томоохон намуудад ашигтай байдаг улс төрийн ерөнхий зүй тогтол байдаг²² зэрэг юм.

Олон намын тогтолцоо. Монголд намуудын зохистой харьцаанд суурилсан олон намын тогтолцоо цаашдаа оршин үйлчлэх боломж байсаар байж болохыг хүлээн зөвшөөрдөг судлаачид нилээд байдаг. Тэдний гаргаж тавьж буй үндэслэл, тайлбарыг тоймлон үзвэл сонирхол татах зүйл нилээд байдаг юм. Энэ нь юуны өмнө парламент дахь намуудын байршил, хүчний харьцаа, үйл ажиллагаанаас үзвэл манайд намуудын харилцааны хоёр биш, харин гурван туйлт харилцаа цаашдаа оршин үйлчлэх нь Монголын өнөөгийн намын системийн гол онцлог гэж тэд батлаад энэхүү намуудын гурван туйлт харилцааны үндэс нь: **нэгд**, улс төрийн либерал үзлийг баримжаа болгосон барууны чиглэлийн; **хоёрт**, социалист социал-демократ зүүний чиглэлийн; **гуравт**, консерватив үзэл хандлага бүхий намууд болж байгаа юм гэж үзэж байна.

Тэдний батлаж байгаагаар одоо Монголд олон намын системийн эхний хоёрын цөм нь үндсэндээ бий болсон. Харин гурав дахь бүрэлдвэр хэсэг нь төлөвшөөгүй, засаглалын системд ч хүч нөлөө байхгүй байгаа юм. Эндээс үзвэл Монголын өнөөгийн хоёр намын шинж төрх бүхий тогтолцоо нь улс төрийн амьдралын тухайн цаг үеийн өвөрмөц онцлогтой уялдсан намын системийн түр зуурын хэлбэр, намын тогтолцооны хөгжлийн тодорхой үе шатны тусгал байж болох юм. Ингэхлээр цаашдаа намын тогтолцооны энэ бүтэц задрах хандлагатай нь ойлгомжтой гэж тэд үздэг.

Манай зарим судлаачид өнөөгийн Монголын намын системийн ерөнхий шинж төрхийг тодорхойлж бичихдээ: “МАХН, Ардчилсан эвсэл гэсэн үндсэн хоёр хүчин, тэдгээрийн аль нэгийг баримжаалсан гуравдагч хүчин гэсэн бүдүүвч нь Монголын улс төрийн амьдралын хамгийн томоохон онцлог юм”²³ гэсэн байна. Энэ бүхнийг үндэс болгон намын системийн олон намын хэлбэр оршин үйлчлэх магадлалтай хэмээн баталдаг судлаачид Монголд цаашдаа төрийн засаглалын тогтвортой үндэс болж чадах улс төрийн төлөвшсөн цөөн хүчтэй намуудаас (3-4) бүрдсэн олон намын тогтолцооны өвөрмөц хэв маяг оршин үйлчлэх магадлал илүү их байгаа юм гэж дүгнэдэг.

Дээр тэмдэглэсэн бүхнээс эцэст нь дүгнэж үзвэл Монголд өнөө оршин үйлчилж байгаа намын систем нь үндсэндээ хоёр намын тогтолцооны ерөнхий шинж төрхийг агуулж байна гэж үзэж болохоор байна. Тэгэхдээ хоёр намын тогтолцоо цаашдаа Монголын намын системийн тогтвортой хэлбэр мөн үү гэдэг дээр судлаачид өнөө хэр маргаж байгаа юм.

Монгол Улс цаашдаа парламентын сонгодог тогтолцоог илүүтэй баримжаалан, түүнийг улам төгөлдөржүүлэх чиглэлээр явна гэж үзэх юм бол тус оронд төлөвшсөн цөөн улс төрийн намуудаас бүрдсэн олон намын сонгодог тогтолцоо илүү нийцэмтэй байж болох талтай. Энэ нөхцөлд сонгуулийн системийн хувь тэнцүүлсэн буюу пропорциональ хэлбэрийг сонгож хэрэглэх шаардлага зүй ёсоор гарч ирнэ. Энд нийгэм дэх социаль бүлгийн ашиг сонирхлын ялгаралын үйл явцын шинж байдал нөлөөлөх нь гарцаагүй. Тэгэхдээ олон намын сонгодог тогтолцоог бүрдүүлэх гол үндэс нь намууд аль болохоор төржсөн хэлбэрээсээ ангижирч, улс төрийн намын сонгодог дүр төрийг олж төлөвших, улс төрийн үнэт зүйлс, үйл ажиллагаагаа тодорхой болгох, Монголын улс төр дэх гуравдагч хүчний хүчтэй блокийг дэмжиж бүрдүүлэх түүний төлөвших улс төр, эрх зүйн болон бусад талын нөхцлийг бий болгох, олон намын тогтолцооны эрх зүйн үндсийг улам боловсронгуй болгох зэрэг наад захын улс төр, эрх зүйн ерөнхий шаардлага, нөхцлийг хангах хэрэгтэй болно. Энэ нөхцөлд Монголын нийгмийн сэтгэл зүй, олон түмний сонирхол нь улс төрийн хоёрхон хүчний нөлөөлөл болон хэт олон намууд оршин үйлчлэхийн аль алиныг нь таашаахгүй байгаа юм. Ингэхлээр Монголд цаашдаа цөөвтөр хүчтэй төлөвшсөн намуудаас бүрдсэн олон намын тогтолцоо оршин үйлчлэх магадлал илүүтэй байж болохоор байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. “Азийн Барометр: *Зуун Ази дахь ардчиллын чанар ба дэглэмийн легитим чанар*” УБ., 2008, 50 дахь тал.
2. “Азийн Барометр: Ардчиллын хөгжлийн харьцуулсан судалгаа” УБ., 2008, 7 дахь тал.
3. Дэлхийн санхүүгийн эдийн засгийн хямрал ба Монгол Улс. УБ., 2009, 132 дахь талд үзнэ үү.
4. Д.Болд-Эрдэнэ. “Монгол дахь ардчилсан өөрчлөлтийн онолын зарим асуудал”. Философи, эрх зүйн судлал. ХХII боть, УБ., 2007
5. “Монгол хагас эрх чөлөөтэй орны жагсаалтад оржээ” гэсэн бэсрэгхэн нийтлэл мэдээнээс үзнэ үү. “Өдрийн сонин” 2010.01. 14. №10.
6. Монголчууд социологийн толинд. ШУА-ийн ФСЭХ-ээс Орос, Англи, Монгол хэлээр гаргадаг судалгааны цуврал товхимол. №1 УБ., 1999. №2, УБ., 2001.
7. Г.Чулуунбаатар. ХХ, ХХI зууны зааг үеийн Монголын улс төрийн өөрчлөлт, ардчиллын хөгжил. УБ., 2009. 248-249 дахь тал.
8. Г.Чулуунбаатар. Засаглалд нааштай өөрчлөлт гараагүй байна. Өдрийн сонин. 2011 №103
9. А.Саруул. “Шилжилтийн үеийн тухай онолын маргаантай асуудлууд”. Шинэ толь 2005 №53.
10. “Монгол Улсын шилжилтийн үеийн улс төрийн намуудын үүрэг” УБ., 2006.
11. Улс төр судлаачдын зарим хэсэг нь хууль ёсны үйл ажиллагаа явуулж буй бүх намуудыг ерөнхийд нь намын системд оруулдаг бол нөгөө хэсэг нь парламентад орж, суудал авсан намуудыг бүхэлд нь намын системд хамруулдаг.
12. Д.Болд-Эрдэнэ “Монголын улс төрийн нам, намын системийн төлөвшил” УБ., 2008.
13. *Тайлбар*: Италийн улс төр судлаач Ж.Сартори нь намын системийг тухайн системд багтаж буй намуудын тоогоор нь 1) ноёрхогч буюу нэг намын систем, 2) хоёр намын систем, 3) хоёр ба хоёр хагас намын систем, 4) гурваас таван намын систем, 5) таваас дээш буюу олон намын систем гэж ангилсан байдаг. (Алан, 1996, х 148-158).
14. “Монголын нийгмийн өөрчлөлт” /Хамтын бүтээл/ УБ., 2008.
15. *Тайлбар*: энэ тухай Л.В. Сморгунов. Намын системийн эмпирик шинжилгээ. / Бодлогын шинжилгээ –II. эрдэм шинжилгээний бичиг /-УБ., 2008- т нийтлэгдсэн өгүүлэлээс үзнэ үү.

16. “Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлт: Монгол дахь засаглалын төлөв байдал, үнэлгээ” УБ., 2006.
17. G.Sartori. “Parties and Party systems”. London. 1976.
18. Э.Гэрэлт-Од. “Монголын ардчилал ба улс төрийн намууд” Шинэ толь. 2005. №52
19. Н.Лүндэндорж. “Олонхийн дарангуйлал”. Өдрийн сонин. 2006. №172
20. Arend Lijphart. Democracy in Plural Societies.
21. Аренд Лийпхарт. “Ардчиллын хэв загвар” УБ., 2008.
22. Дуглас В.Рай “Сонгуулийн эрхийн улс төрийн нөхцөл” /англи хэл дээр/
23. Ганхуяг. “Намуудын мандал ба бууралт”. Өдрийн сонин. 2005 №286.